



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№84 /528/

2023.05.24

Цаг үе, үйл явдал

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛДААНААР...



Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн ээлжит хуралдаан өнөөдөр буюу 2023 оны тавдугаар сарын 23-нд болж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

1. ҮБХИС-ийн БХУА, ЦНДС, Цэргийн хөгжмийн

коллеж, Батлан хамгаалахын мэргэжил сургалт-үйлдвэрлэлийн төвд 2023-2024 оны хичээлийн жилд элсэлт авах мэргэжил, хяналтын тоог хэлэлцэж баталлаа.

2. Жил бүрийн 11 дүгээр сарын 9-ний өдрийг

Зэвсэгт хүчний Ахлагчийн албаны тэмдэглэлт өдөр болгохоор шийдвэрлэв.

3. Байнгын комиссын бүрэлдэхүүн, БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагаас зохих материалаа бүрдүүлэн сонгон шалгаруулалтад хамрагдаж тэнцсэн 14 цэргийн алба хаагчийн мэдээлэлтэй танилцаж БНӨСУ, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Йемен, Мали, Баруун сахар, Абэ муж зэрэг долоон улсын нутаг дэвсгэрт явагдаж буй НҮБ-ийн энхийг сахиулах ажиллагаанд штабын ажилтан, цэргийн мэргэжилтнээр үүрэг гүйцэтгүүлэхээр болов.

4. Монгол Улс, Австралийн Холбооны Улсын Батлан хамгаалах яамд хоорондын наймдугаар зөвлөлдөх уулзалтын тухай хуралдаанаар хэлэлцлээ.

5. Батлан хамгаалахын сайдаар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс 17-ны өдрүүдэд Өмнөговь, Дундговь аймгуудад байрлах Зэвсэгт хүчний 167 анги, 124 дүгээр ангийн харьяа нэг салбар, 065 дугаар ангийн харьяа гурван салбаруудад ажилласан тухай хэлэлцэж зарим анги, салбаруудын цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчлэх, барилга байгууламжийг сэргээн засварлахаар шийдвэрлэв.

6. ҮБХИС-ийн харьяа Аюулгүй байдлын дээд сургуулийн үйл ажиллагаанд хийсэн хяналт- шинжилгээг Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж барилга байгууламжийн засвар үйлчилгээ, алба хаагчдын нийгмийн хамгааллыг нэмэгдүүлэх, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөхөөр болов.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 16	☁️ 0

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 40	☁️ 27

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,451	3,456
EUR 🇪🇺	3,725	3,750
CNY 🇨🇳	490	492.50
RUB 🇷🇺	43	43.40
JPY 🇯🇵	25.10	25.50
KRW 🇰🇷	2.61	2.63

ЗУРХАЙ

2023.05.24 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 5

ЗУНЫ ТЭРГҮҮН УААГЧИН МОГОЙ САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ХАР МОРЬ ӨДӨР

Үс засуулбал:

Эд мал, сайжирна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.04-20.34

Барилдлага:

Үхэх

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Авахуй

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүлштэй. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, эм найруулах, гэргий авах, үс авах, элч зарах, эд авахад сайн. Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол гаслан болох, нохой уливал галзуурах, хэрээ гуаглавал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэнэт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болтой.

"БИДНИЙ БАХАРХАЛ" ТӨСӨЛ БУЛГАН АЙМГИЙН САЙХАН СУМАНД...



Батлан хамгаалах хууль тогтоомжийг Булган аймагт сурталчлах "Бидний бахарал" төсөл Сайхан суманд хэрэгжиж байна. Төслийн арга хэмжээг Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай нээж үг хэллээ. Мөн нутгийн иргэд хөдөлмөрчид хүүхэд залуучуудад Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлого үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй танилцуулга хийлээ.

Түүнчлэн эх орныхоо хөгжил цэцэглэлтэд өөрийн үнэтэй хувь нэмэрээ оруулж хөдөлмөр зүтгэлээ зориулан ажиллаж байгаа сумын зарим удирдлага, ахмад дайчдад Батлан хамгаалахын сайдын тушаалаар Батлан хамгаалах салбарын шагнал, дурсгалын зүйл гардууллаа. Тодруулбал "Эх орны төлөө II" хүндэт тэмдгээр Сайхан сумын

ИТХ-ын дарга Л.Пүрэвсүрэнг, "Эх орны төлөө III" хүндэт тэмдгээр Сайхан сумын Засаг дарга Д.Сансар-Очирыг, Дурсгалын зүйлээр Засаг даргын орлогч Т.Батжаргалыг, ЗДТГ-ын дарга С.Лувсанцоодол 3 дугаар багийн Засаг дарга Д.Дэмчигсүрэн нарыг тус тус шагналаа.

Энэхүү арга хэмжээний дараа Сайхан сумын ард иргэд, хүүхэд залуучуудад "Тусгаар тогтнолын үнэ цэн", "Энхийн үйлсэд 20 жил" баримтат киног сонирхууллаа. Хөтөлбөрийн төгсгөлд Байлдааны гавьяаны улаан тугийн болон Байлдааны гавьяаны одонт ЦДБЭЧ-ын уран бүтээлчид хүндэтгэлийн тоглолтоо өргөн барьсан юм.

Дэслэгч Б.ЭРДЭНЭБАТ

"ЦОГЛОГ" ЦЭЦЭРЛЭГИЙН БАГАЧУУД ИХИЙГ СУРЧЭЭ



Батлан хамгаалах яамны харьяа "Цоглог" цэцэрлэгийн багачууд 2022-2023 оны хичээлийн жилд сурч мэдсэн дуу шүлэг, бүжиг, хөгжимт үзүүлбэрээрээ бэлтгэсэн тоглолтоо эцэг эхчүүддээ толилуулж, өглөөлгийн үйл ажиллагаагаа амжилттай зохион байгууллаа.

Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний алба хаагчдын үр хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох чиглэлээр 2-5 настнуудыг хүлээн авч, хүмүүжүүлэн хөгжүүлдэг "Цоглог" цэцэрлэг нь Баянзүрх дүүргийн 115 дугаар цэцэрлэгийн харьяанд үйл ажиллагаагаа явуулдаг. 12 бүлэг, нэг гэр цэцэрлэг болон "Цоглог"-ийн салбарын бүрэлдэхүүнтэй тус цэцэрлэгийн эрхлэгч С.Мөнхжаргал энэ хичээлийн жилд ихийг сурч мэдсэн хүүхэд багачууд, тэднийг хүмүүжүүлсэн багш нар, хүүхдийнхээ төлөө цэцэрлэгтэйгээ нягт хамтран ажилласан эцэг эхчүүддээ эрдмийн баярын мэнд хүргээд, ирэх намар сургуулийн сурагч болохоор цэцэрлэгээ төгсөж байгаа Бэлтгэл бүлгийн дөч гаруй шавь нартаа амжилт хүсэв. Энэ жил

тус цэцэрлэгийн хүүхдүүд соробан самлин, шатар даамны нэмэлт сургалтад хамрагдсан бөгөөд анх удаа "Ногоон гэрэл-цагаан шугам" тэмцээнд оролцоод, шагналт байр эзэлжээ.

Салбарын ирээдүй болсон үр хүүхдүүдийн маань сурч боловсрох аятай

тухтай нөхцөлийг бүрдүүлж, хүүхдийн хөгжиж дэвших бололцоог хангаж, сургуулийн өмнөх боловсролыг чанартай олгож, авьяас чадварыг нь олон талаар хөгжүүлж байгаа цэцэрлэгийн хамт олондоо эцэг эхчүүд, шавь нарынх нь өмнөөс талархлаа илэрхийлье.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 689,124,038

Эдгэрсэн

Нийт: 661,546,999

Нас барсан

Нийт: 6,881,401

Цахим шууданд

"БИДНИЙ БАХАРХАЛ" ТӨСЛИЙН АРГА ХЭМЖЭЭ БУЛГАН АЙМГИЙН СЭЛЭНГЭ СУМАНД ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



Батлан хамгаалахын хууль тогтоомжийг сурталчилж, "Бидний бахархал" төслийг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээ Булган аймгийн сумдад үргэлжилж байна. Энэ хүрээнд тус аймгийн Сэлэнгэ сумын иргэд, ЕБС-ийн сурагчид,

төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдад танилцуулга мэдээллийг хүргэж, тодорхой сэдвүүдээр лекц уншлаа. Тодруулбал, БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга хурандаа Р.Энболд Батлан хамгаалах хууль тогтоомж,

бодлого үйл ажиллагааны талаар мэдээлэл хийсэн бол ҮБХИС-ийн ахмад багш бэлтгэл хурандаа С.Энхтайван "Залуучуудын эх оронч үзэл хүмүүжлийн онцлог асуудлууд" сэдвээр лекц уншсан юм. Мөн тус сумын ЕБС-ийн сурагчдын дунд сагсан бөмбөгийн 3х3 тэмцээнийг зохион байгуулж гүүрүүлсэн багийн тамирчдад БХЯ-ны "Шонхор" хүүхдийн зусланд амрах эрхийн бичиг гардуулав. Түүнчлэн Монгол Улсын Зэвсэгт хүчин цэргийн алба хаагчдаа энхийг дэмжих ажиллагаанд оролцуулж эхэлсний 20 жилийн ойд зориулан бэлтгэсэн "Энхийн үйлсэд 20 жил", эх орон, эх түүхээрээ бахархах үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн "Тусгаар тогтнолын үнэ цэн" баримтат киног хүрэлцэн ирсэн иргэд, хүүхэд залуучуудын хүртээл болголоо. Арга хэмжээний төгсгөлд ЦДБЭЧ-ын уран бүтээлчид хэсэгчилсэн урлагийн тоглолтыг толилуулсан юм. Үргэлжлүүлэн Байлдааны гавьяаны улаан тугийн болон "Алтан гадас" одонт Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн Үлээвэр найрал хөгжмийн алба хаагчид дуут жагсаалын үзүүлбэр, хугацаат цэргийн алба хаагчид жагсаалын, Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн цэргийн алба хаагчид гардан тулааны үзүүлэх тоглолтыг сумын нийт иргэд, хүүхэд залууст сонирхуулав.

БУЛГАН АЙМГИЙН МОГОД СУМАНД БАТЛАН ХАМГААЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ СУРТАЛЧИЛЛАА



Батлан хамгаалах хууль тогтоомжийг ард иргэдэд сурталчлан таниулах, эх оронч үзэл төлөвшилтэй ирээдүй хойч үеийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой "Бидний бахархал" төсөл Булган аймгийн сумдад амжилттай хэрэгжиж байна. Тухайлбал, Энэ өдөр Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай танилцуулж, ЦДБЭЧ-ын уран бүтээлчид

харьяа байгууллагын удирдлагууд болон бие бүрэлдэхүүний төлөөллүүд Булган аймгийн Могод суманд ажиллалаа. "Бидний бахархал" төслийн хүрээнд нутгийн ард иргэдэд Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлого үйл ажиллагааны талаар Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай танилцуулж, ЦДБЭЧ-ын уран бүтээлчид

хүндэтгэлийн тоглолт, БХТА Архивын лавлагаа мэдээлэл, Монгол цэргийн музей "Түүх өгүүлсэн он жилүүд" үзэсгэлэн, Алдар спорт хороо 3х3 сагсан бөмбөг, шатрын тэмцээнийг тус зохион байгуулав. Өдөрлөгийн үеэр Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн гардан тулааны үзүүлбэр, жагсаалын үзүүлэх тоглолт, Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн зэвсэг, шүхэр, шүхрийн дагалдах хэрэгслийн үзэсгэлэн, Цэргийн хөгжмийн политехникийн коллежийн сонсогчид Үлээвэр найрал хөгжмийн үзүүлэх тоглолтоо сонирхуулсан нь Булган аймгийн Могод сумдын иргэд хөдөлмөрчид, хүүхэд залуучуудын бахархал хүндлэлийг хүлээсэн үйл явдал болсон юм. Ташрамд

дуулгахад уг сум нь 1691 онд Халхын Түшээт ханы хошуунд харьяалагдаж байгаад 1912 оноос Сундуй гүний, 1924 оноос Богд хан уулын аймгийн Авзага хайрхан уулын, 1931 онд Архангай аймгийн харьяанд Могод сум нэртэйгээр үүсэн байгуулагджээ. Эл нутгийн хувьд "Баян", "Могод", "Жаргалант", "Түлээ", "Дулаан хар" зэрэг өндөр сүрлэг уулс, хайрхнууд болон Их, бага "Тогоо" хэмээх сөнөсөн галт уулын байгалийн өвөрмөц тогцоороо алдартай аж. Мөн түүнчлэн "Орхон", "Баянгол", "Хульж", "Бумбат", "Жаргалант", "Уртын гол"-ууд тус сумыг дайран урсах бөгөөд "Хульж" гэх халуун, хүйтэн рашаантайгаас үзвэл эх газрын эрс, тэс уур амьсгалтай нутаг болох нь ажиглагдана.

СТРАТЕГИЙН КОМАНД ШТАБЫН СУРГУУЛЬД ОРОЛЦОГЧДОД НЭГДСЭН МЭДЭЭЛЭЛ ӨГЛӨӨ



Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газар хамтран "Нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдол "онц байдал" тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа" сэдэвт стратегийн команд штабын сургуулийг ирэх зургаадугаар сарын 7-9-ний өдрүүдэд зохион байгуулна. Сургуульд яам агентлаг, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөл болон 21 аймгийн Онцгой комиссын гишүүд оролцох юм.

Стратегийн команд штабын сургуульд оролцогчид Онцгой байдлын ажиллагааны удирдлагын төвийн бүтцээр ажиллаж, харилцан уялдаа холбоо, ослын удирдлагын систем, онцгой байдлын ажиллагааны төв /Нэгдсэн шуурхай штаб/, хүмүүнлэгийн олон улсын байгууллага, төрийн цэргийн байгууллагын чиг үүргийг уялдуулах зорилгоор газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх штабын дадлага хийнэ. Үүнтэй холбогдуулан Сургуулийн удирдагч, ОБЕГ-ын дэд дарга, бригадын генерал Б.Ууганбаяр сургуульд оролцогчдод нэгдсэн мэдээлэл, холбогдох үүрэг чиглэл өглөө.



"ХААНЫ ЭРЭЛД"-ИЙН ХҮРЭЭНД ЦЭРГИЙНХНИЙ БАРЬЖ ӨГСӨН ДОТУУР БАЙРАНД 12 СУМЫН СУРАГЧИД АМЬДАРЧ БАЙНА



"Хааны эрэлд-2023" олон улсын энхийг дэмжих сургууль тун удахгүй эхлэх гэж байна. Монгол Улсын Зэвсэгт хүчин, АНУ-ын Энэтхэг-Номхон далайн командлалын хамтарсан энэхүү сургууль 2003 онд эхэлсэн цагаасаа хойш цэргийн хамтарсан сургалт, дадлагаас гадна нийгэмд чиглэсэн олон бүтээлч ажил өрнүүлсний нэг нь 2016 онд Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын IV сургуулийн дотуур байрыг барьж өгсөн явдал байв.

Монгол, Америк, Энэтхэг, Сингапурын цэргийн ах, эгч нарынхаа барьж өгсөн дотуур байранд амьдарч байгаа сурагчдын нэг өдөртэй танилцахаар Зуунмод сумын Зүүндэлгэр багт байрлах IV сургуульд хичээлийн цаг тарахтай нь зэрэгцүүлэн зорин очлоо. Сургууль, цэцэрлэг, дотуур байр нь нэг дороо байрласан байх агаад гадаа нь ахлах ангийн сурагчид сагсан бөмбөг, гар бөмбөгөөр, багачууд нь дээсээр тоглож, инээд хөөр цалгисан орчин биднийг угтав. Сурагчийн дотуур байрны гадаах амралтын саравчид хоёр сурагч охин сууж байсан нь 6 настай Н.Амгаланзаяа, 8 настай Б.Анирбилэг. Тэд дотуур байрны сурагчдаас хамгийн бага нь Б.Анирбилэг ойр зуурыг өгүүлэх зууртаа л өөрийгөө Батсүмбэр сумынх, эхээс дөрвүүлээ. Шүү өвддэг учраас ирээдүйд шүдний эмч болно, нэгдүгээр ангиасаа хойш дотуур байранд амьдарч байгаа гэж танилцуулав. Тэр бас "Цэргийн ах, эгч нар энэ барилгыг бидэнд барьж өгсөн гэсэн үг" хэмээн лавлаж байлаа.

Энэ өдөр байрны жижүүрээр Б.Цогцолмаа гэдэг эмэгтэй гарч, хүүхдүүдийг цэргийн сурвалжлагчаар бүгдээрээ зургаа авахуулна, ярилцлага авбал миний хүүхдүүд ичиггүй сайхан яриарай гээд уриалах нь дотно сайхан сонсогдож байв. Дотуур байранд багш, тогооч, гурван жижүүр гээд 5 хүн ажилладаг бөгөөд цөмөөрөө бүсгүйчүүд ажээ. Багш Г.Одонтуяагийн өгсөн мэдээллээр 2022-2023 оны хичээлийн жилд Төв аймгийн 12 сумын 36 сурагч байранд амьдарч байгаа гэнэ. Байрны хүчин чадал нь өөрөө 35 хүүхдийн багтаамжтай санж. Сурагчдын олонх нь дунд, ахлах ангийнх, аав ээжийнх нь хүсэлтээр цөөн тооны бага ангийн сурагчийг ах, эгчийнх нь хамт байрлуулжээ. Байрны хувьд 2016 онд баригдаж ашиглалтад орсон цагаасаа хойш урсгал засвар хийснийг эс тооцвол чанартай барилга гэдгийг багш онцолж байв. Сурагчид амьдрах 9 тасагтай, гал тогоо, соёл амралтын өрөөтэй. Хөдөө сумдын дотуур байрны сурагчдад хамгийн их тулгардаг гадаах бие засар газар гэж "зовлон" тэдэнд үгүй. Халуун хүйтэн ус, дулаан хангамж болон бие засах газар, усанд орох өрөөг нь эрэгтэй, эмэгтэйдгээр нь ялгаж, цогцоор нь барьж өгсөн, яг л тэр хэвээрээ ажээ.

Г.Одонтуяа багш МУИС-ийг нийгмийн ухааны багш мэргэжлээр төгссөн, "Хааны эрэлд"-ийн хүрээнд дотуур байр баригдаж ашиглалтад орсон цагаас нь хойш ажиллаж байгаа бүсгүй байна. Тэрээр "Өмнө нь дотуур байр гэж байгаагүй. Сумдын сурагчид маань айл дамжин амьдарч, эцэг эхэд нь ч хүндрэлтэй байдаг байсан. 2016 оноос харин байр ашиглалтад орсноос хойш эцэг, эхийн нар гарсан даа. Цэргийнхэндээ сурагчид тэдний эцэг эх, сургуулийнхаа захиргааны нэрийн өмнөөс баярлаж явдгаа дахин дахин уламжилъя" хэмээн талархал дэвшүүлж байсан юм.

Тасгуудаар орлоо. Нэгэн айлын эгч дүү гурав байсан нь Сэргэлэн сумын малчин Д.Дагвацэрэн, С.Энхтуяа нарын хүүхдүүд болох Д.Марал, Д.Сэржиддамба, Д.Санжаадамба нар. Эгч нь 11 дүгээр анги, хоёр дүү нь долоо болон дөрөвдүгээр ангийнх. Д.Марал байр ашиглалтад орсноос хойш 6 дахь жилдээ амьдарч байгаа, тохитой дулаахан, миний хоёр дахь гэр өөриймсөг нь араггүй өгүүлж байв. Ирэх жил бага дүү нь сургуульд орохоор дөрвүүлээ амьдарна, нийгмийн ухаан, хуулийн аль нэг чиглэлээр нь мэргэжил эзэмшихээр төлөвлөсөн, зуныхаа амралтаар аав, ээждээ тусалж ямаа, гүү сааж, гар хөлийнх нь үзүүрт тусалдаг гэж байна. Аав, ээж нь 2022 онд сумын аварга малчнаар тодорсон ажилсаг бүл ажээ. Тэдэнтэй нэг өрөөнд амьдрах Аундарь 10 дугаар анги, Баянцагаан сумын сурагч гэнэ. Энэ үед сурагчдад аймгийн ЭМГ-ын мэргэжилтнүүд "Эрүүл зөв амьдралын хэвшил болон халдварт өвчлөл" гэсэн сэдвээр сургалт явуулж таарав.

Энэ байранд чөлөөт бөхийн улсын аваргын алт, хошой мөнгөн медальт, Азийн аваргын тусгай байрын шагналт Э.Одгэрэл гэдэг 12 дугаар ангийн спортлог сурагч бас байна. Ашиглалтад орсон цагаас хойш амьдарч байгаа сурагчдын нэг тэрээр 2020 онд чөлөөт бөхийн улсын аваргаас алт, 2022, 2023 онд хос мөнгөн медаль хүртэж, аймаг, сумандаа ч гаргасан амжилт их санж. Чөлөөт бөхөөс гадна сагсан бөмбөг, гар бөмбөгөөр хичээллэдэг, энэ жил ҮБХИС эсвэл ДХИС-д элсэхээр элсэлтийн ерөнхий шалгалтдаа бэлтгэж буйгаа дуулгаад "Өнөөдрийн тав тухтай орчин нөхцөлийг бүрдүүлж өгсөн Монгол, Америк цэргүүддээ баярлалаа" гээд хоёр дүү нь ярилцлага өгөх гээд хүлээж байгаа хэмээн өрөөнд нь дагуулж орлоо. Ес болон долоодугаар ангийн сурагч Ц.Алтаншагай, Б.Энхбаяр нар ирээдүйд цэргийн хүн болно, хурдан морь унаж өссөн, удахгүй ангийнхантайгаа мод тарина, гэрийнхнээ нэг их санадаггүй, байрныхаа бүх хүүхдүүдтэй найз, тогооч Б.Сарангэрэл эгчийн бэлтгэсэн хоол бүхэн амттай хэмээн тодотгож байлаа.

Энэ өдөр хүүхдүүдээ эргэж тойрохоор хөдөөнөөс зарим эцэг, эх ирсэн байх агаад тэд мөн л цэргийнхэндээ талархаж байна, малчид бидэнд нэн хэрэгцээтэй байсан асуудлыг олж шийдвэрлэсэн нь ирээдүйд оруулж буй үнэлж баршгүй хувь нэмэр билээ гэсээр хүүхдүүдтэйгээ инээмсэглэсээр дурсгалын зургаа татууллаа.

Ахмад Д.БОЛОР